

НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ

Товч удирдамж: Шүүхийн ерөнхий зөвлөлийн эсхүл Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвших тухай хүсэлт гаргахдаа энэхүү загварт асуусан асуулт, шаардсан мэдээлэл бүрийн дор /ард/ хариултаа үнэн зөв, бүрэн дүүрэн бичнэ. Компьютерын програм ашиглаж бичсэн хүсэлтийг цаасаар хэвлэж гарын үсэг зурах бөгөөд уг эх хувь, түүний хавсралтыг Хууль зүйн байнгын хороонд хүргүүлнэ. Мөн, нэр дэвших тухай хүсэлтийг Word-ын файлаар цахим шуудан /сонгон шалгаруулах тухай зард заасан хаяг/-аар тус байнгын хороонд явуулна.

НЭГ. ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА:

1.1	Эцэг/эхийн нэр: Доржгочоо Ургийн овог: Доржгочоо Нэр: Ариунтуяа . Хүйс: Эмэгтэй
1.2	Нэр дэвших тухай хүсэлт гаргаж буй албан тушаал Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүн
1.3	Иргэний харьяалал Монгол Улсын иргэн мөн үү /тийм эсхүл үгүй гэж бичих/. Тийм
1.4	Насны дээр хязгаар Төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн үү /тийм эсхүл үгүй гэж бичих/. Үгүй
1.5	Улс төрийн болон намын удирдах албан тушаал Сүүлийн таван жил улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаа юу, эсхүл эрхэлж байсан уу /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, ямар албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа эсхүл эрхэлж байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/. Үгүй
1.6	Шүүгчийн албан тушаал Шүүгчээр ажиллаж байгаа юу, эсхүл ажиллаж байсан уу /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, аль шүүхэд ямар хугацаанд шүүгчээр ажиллаж байгаа эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/. Үгүй
1.7	Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр ажиллаж байгаа юу, эсхүл ажиллаж байсан уу /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, уг албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.

	Үгүй
1.8	<p>Шүүхийн сахилгын хорооны гишүүн Шүүхийн сахилгын хорооны гишүүнээр ажиллаж байгаа юу, эсхүл ажиллаж байсан уу /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, уг албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p>Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас нэр дэвшүүлэн 2019 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 206 дугаар зарлигаар Шүүхийн Ёс зүйн хорооны гишүүнээр томилогдон ажиллаж байна.</p> <p>2019 оны 11 дүгээр сараас одоог хүртэл</p>
1.9	<p>Шүүхийн захиргааны байгууллагын ажилтан Шүүхийн захиргааны байгууллагын ажилтны ажил, албан тушаал эрхэлж байгаа юу, эсхүл эрхэлж байсан уу /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, уг ажил, албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p>Үгүй</p>
1.10	<p>Хуульч Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй юу, эсхүл ийм зөвшөөрөлтэй байсан уу /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, уг зөвшөөрлийг ямар хугацаанд эзэмшиж байгаа эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p>Үгүй</p>
1.11	<p>Өмгөөлөгч Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхтэй юу, эсхүл ийм эрхтэй байсан уу /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, уг эрхийг ямар хугацаанд эдэлж байгаа эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p>Үгүй</p>
1.12	<p>Прокурор Прокурорын албан тушаал эрхэлж байгаа юу, эсхүл байсан уу /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, уг албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p>Үгүй</p>
1.13	<p>Эрүүгийн хариуцлага Эрүүгийн хариуцлага хүлээж байсан уу /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p>Үгүй</p>
1.14	<p>Сахилгын шийтгэл Сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж эсхүл огцорч байсан уу /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p>Үгүй</p>

ХОЁР. ХИЙХ АЖИЛ, НЭР ДЭВШСЭН ҮНДЭСЛЭЛЭЭ БИЧСЭН ТАЙЛБАР

2.1	<p>Шүүхийн ерөнхий зөвлөлийн эсхүл Шүүхийн сахилгын хорооны гишүүний хувьд хийх ажил, уг албан тушаалд нэр дэвшсэн үндэслэлээ тайлбарлаж тодорхой, ойлгомжтой бичнэ /энэ хоёр албан тушаалын аль нэг орон тоог нь сонгож, тайлбарыг 500-1000 үгэнд багтаана/</p> <p>Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Үндсэн хуулийн 6 дах хэсэгт заасны дагуу хуульд заасан үндэслэл журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бусад шийтгэл ногдуулах чиг үүрэг бүхий Шүүхийн сахилгын хороо ажиллахаар заасан.</p> <p>Түүнчлэн Монгол Улсын Их Хурлаас баталж 2021 оны 3 дугаар сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэн Шүүхийн тухай хуулиар Шүүхийн сахилгыг хороог бие даан байгуулж мөн хорооны гишүүдийг орон тооны байхаар хуульчилж сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлж өгсөн билээ.</p> <p>Миний хувьд Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тасралтгүй 22 жил ажиллахдаа бодлого боловсруулах, хууль тогтоомжийн төсөл боловсруулах, захиргааны хэм хэмжээний актын үндэслэл хянах, улсын бүртгэлд бүртгэх зэрэг хариуцлагатай албыг эрхэлж байна.</p> <p>Түүнчлэн Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас нэр дэвшүүлэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 11 дүгээр сарын 20-ны 206 дугаар зарлигаар Шүүхийн ёс зүйн хорооны гишүүнээр томилсон бөгөөд гишүүдийн бүрэлдэхүүн хүрэхгүйн улмаас 2020 оны 12 дугаар сарын сүүл хүртэл шүүхийн ёс зүйн хороо хуралдаж гомдлыг хянан шийдвэрлэх боломжгүй байлаа. Ингээд 2020 оны 12 дугаар сард нийт 6 гишүүн томилогдож даргаа сонгосноор одоо Шүүхийн ёс зүйн хорооны үйл ажиллагаа хэвийн үргэлжилж байна. Ажиллах хугацаандаа Шүүхийн ёс зүйн хороонд ирсэн 38 гомдлыг хүлээн авч, хуралдаанаар 14 гомдол, сахилгын хэргийг хянан шийдвэрлүүлж, бусад гишүүдийн 30 гомдол, сахилгын хэрэг хянан шийдвэрлэх хуралдааны бүрэлдэхүүнд ажиллалаа.</p> <p>Шүүхийн Ёс зүйн хороо 2013-2020 оны байдлаар давхардсан тоогоор 2334 шүүгчид холбогдох 1586 гомдол хүлээн авснаас 80 гаруй хувьд нь сахилгын хэрэг үүсгэхээс татгалзаж, 20 орчим хувьд сахилгын хэрэг үүсгэн шалгаж, шүүгчид сахилгын шийтгэл ногдуулсан 75 магадлал гаргасны, 6 магадлалыг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс дахин хэлэлцүүлэхээр буцааж, нийт 69 шүүгчид сахилгын шийтгэл ногдуулсан байна. Шүүгчид сахилгын шийтгэл ногдуулсан магадлалын 74 хувь нь шүүгчийн гаргасан сахилгын зөрчлийн хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн, шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зөрчил, сахилгын хэрэгт авагдсан баримтаар сахилгын шийтгэл хүлээлгэж болохгүй гэх үндэслэлээр шүүхийн шатанд хэрэгсэхгүй болж, энэ хугацаанд 18 шүүгч шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр сахилгын шийтгэл хүлээсэн байна.</p> <p>Өөрөөр хэлбэл шүүхийн багц хуулийг 2013 онд баталж хэрэгжих хугацаанд жил тутам 510 гаруй шүүгч ажиллаж тэдгээрийн 30 орчим хувьд шүүгч ёс зүйн зөрчил гаргасан гэж гомдол гаргадаг боловч сүүлийн 6 жилийн</p>
------------	--

хугацаанд 18 шүүгч шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр сахилгын шийтгэл хүлээсэн нь хариуцлагын систем сайн ажиллаагүйг илэрхийлж байна. Сүүлийн үед шүүгчийн талаарх олон нийтийн хардлага, эсэргүүцэл, эгдүүцэл нэмэгдэж иргэдийн шүүхэд итгэх итгэл суларч, нийгэм дэх хариуцлагын хэмжүүр доройтож байна.

Иргэдийн шүүхэд хандах хандлага, итгэл суларч, шүүх шүүгчээс шударга ёсыг хүсэж буй өнөө үед төрөөс баримталж байгаа бодлого, шинээр батлагдсан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хариуцлагын тогтолцоог сайжруулах, төлөвшүүлэх чухал цаг хугацааны үед улс орны эрх ашиг, ард түмний шүүхэд итгэх итгэлийг бэхжүүлэх, шударга ёсны хэмжүүрийг дээшлүүлэхэд бодит хувь нэмрээ оруулах нь зүйтэй гэж үзлээ.

Миний бие хууль тогтоомжоор тогтоосон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд тавигдах шаардлагыг бүрэн хангаж байгаа тул Шүүгчийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэрээ дэвшүүлж шүүхийн хариуцлагын тогтолцоог сайжруулах ажлын хүрэнд дараах ажлыг хийж гйцэтгэхээр санал болгож байна.

Нэг. Гомдол шалган шийдвэрлэх ажлын хүрээнд:

1. Иргэд, албан тушаалтан, хуулийн этгээдээс гаргасан гомдлыг тогтоосон хугацаанд бодитой шалгаж шуурхай шийдвэрлэхэд хүчин чармайлт гаргаж, манлайлан ажиллах;
2. Сахилгын хороонд гаргасан гомдол, түүний шийдвэрлэлтийн талаар судалгааны ажил хийж, олон нийтийг мэдээллээр хангах;
3. Аливаа гомдол, хүсэлт, маргааныг шийдвэрлэхдээ шүүгчийн онцлог мэргэжил, хараат бус, халдашгүй байдлын талаар эрх зүйн индекс өндөртэй улс орнуудын сайн туршлага, олон улсын зөвлөмж, баримт бичгийг судалж үндэсний хууль тогтоомжид нийцүүлэн уялдуулахад хамтран ажиллах.

Хоёр. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:

1. Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын Сахилгын хороотой холбогдох заалтыг олон нийтэд сурталчлан таниулах, сахилгын тогтолцооны бие даасан байдлыг хангахад чармайн ажиллах;
2. Шүүгчийн сахилга, хариуцлага урамшуулал, идэвхжүүлэлтийн системийг нэгтгэх; /урамшууллыг бий болгох, сахилга, хариуцлагатай уялдуулах/
3. Шүүхийн сахилгын хороо нь орон тооны ажиллаж байгаагийн хувьд шүүхийн систем дэх хариуцлагын асуудлыг нэгтгэн шалгаж эцэслэн шийдвэрлэх; /Тухайлбал: Шүүхийн захиргааны удирдах ажилтны сахилга хариуцлага/
4. Шүүгчийн ёс зүй, сахилга хариуцлагын талаар урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах.

Дээр дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлснээр шүүхийн хариуцлагын тогтолцоо бэхжиж, шүүхийн шинэтгэлийн цогц систем бүрдэхэд бодит нөлөө үзүүлнэ гэж үзэж байна.

	<p>Миний бие Шүүхийн сахилгын хорооны гишүүнээр томилогдвол Монгол Улсын Үндсэн хууль болон Шүүхийн тухай хуульд заасан чиг үүргээ хэнээс ч хараат бусаар хэрэгжүүлж, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандаж, шүүгчид холбогдох сахилгын хэрэг маргааныг хуульд нийцүүлэн хянан шийдвэрлэхэд аливаа ашиг сонирхлоос ангид байж, мэдлэг, туршлага, чадвараа дайчлан ажиллах болно.</p>
--	--

ГУРАВ. МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАНИЛЦУУЛГА

Д/д	Шалгуур үзүүлэлт
3.1	<p>Боловсрол Дээд боловсрол эзэмшсэн сургууль тус бүрийг сүүлд төгссөн сургуулиас нь эхлэн он дарааллаар жагсааж, холбогдох нотлох баримтыг хавсаргана. Сургууль тус бүрд суралцсан хугацаа, авсан зэрэг, огноог бичнэ.</p> <ul style="list-style-type: none"> • БНСУ-ын Кенхи Их сургуульд хууль зүйн магистрын зэрэг хамгаалсан. 2006-2009 • МУИС Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр, 1996-1999 бакалавр • ММИС монгол судлаач мэргэжлээр, бакалавр 1992-1996
3.2	<p>Эрх зүйч мэргэжлээр ажилласан байдал Хүсэлт гарагч нь эрх зүйч мэргэжлээр ажилласан ажлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар тодорхойлон бичих бөгөөд ажил тус бүрийг эрхэлж байсныг нотлох баримтыг хавсаргана. Ажил тус бүрийг тодорхойлохдоо дараах мэдээллийг заавал бичнэ:</p> <ul style="list-style-type: none"> -албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа; -ажлын байрны тодорхойлолтын гол агуулга; -удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/; -тухайн албан тушаал эрхэлж байхдаа хамтран ажиллаж байсан, өөрийн удирдлагад ажиллаж байсан, ажил хэргийн харилцаатай байсан таваас доошгүй хүний нэр /нэрс аль болох давхцахгүй байх/, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/. <ul style="list-style-type: none"> • ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийн хэлтсийн даргаар 2016 оноос одоог хүртэл ажиллаж байна. <p><u>Удирдлага:</u> Энэ хугацаанд тус яамны Төрийн нарийн бичгийн даргаар Г.Баясгалан одоо Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр ажиллаж байгаа, Г.Билгүүн одоо Иргэний бүртгэлийн ерөнхий газрын дэд даргаар ажиллаж байгаа, Б.Баасандорж одоо ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар ажиллаж байгаа</p> <p><u>Ажлын байрны тодорхойлолтын гол агуулга:</u> Монгол Улсын Засгийн газрын гишүүн, УИХ-аас байгуулдаг байгууллагаас гаргасан шийдвэр, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчид, Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга болон хуулиар хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргахаар тусгайлан эрх</p>

олгогдсон бусад байгууллага, газар, зөвлөл, хороо, төв, хүрээлэн зэрэг байгууллагын Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг хянах, бүртгэх, улсын нэгдсэн санг эрхлэн хөтлөх, лавлагаа, мэдээллээр олон нийтийг хангах ажлыг удирдан зохион байгуулах

Хамтран ажиллаж байгаа хүмүүс:

Э.Сэлэнгэ одоо ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийн хэлтсийн ахлах шинжээч

М.Мөнх-Алдар одоо ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийн хэлтсийн шинжээч

Б.Даваасүрэн одоо ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Т.Нарантунгалаг одоо ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын шинжээч

Л.Пүрэвсүрэн одоо ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын мэргэжилтэн

- **ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газар, Эрх зүйн шинэтгэлийн бодлогын газрын мэргэжилтэн, ахлах мэргэжилтнээр 2000-2016**

Удирдлага: Энэ хугацаанд Хууль зүйн бодлогын газрын даргаар Ц.Цолмон одоо Эрдэнэс таван толгой ХК-ийн дэд захирлаар ажиллаж байгаа, Т.Бат-Өлзий одоо ХЗДХЯ-ны Олон улсын гэрээ, гадаад хамтын ажиллагааны газрын даргаар ажиллаж байгаа.

Ажлын байрны тодорхойлолтын гол агуулга:

Эрх зүйн шинэтгэлийн стратегийг төлөвлөх, эрх зүйн шинэтгэлийн бодлогыг хэрэгжүүлэх, үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хэрэгжүүлэхэд мэргэжлийн зөвлөлгөө өгөх. Үүнд:

- Хариуцсан чиглэлийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар судалгаа хийх;
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлд хариуцсан чиглэлийн асуудлыг тусгах санал боловсруулах;
- Хариуцсан чиглэлээр боловсруулж ирүүлсэн хуулийн үзэл баримтлалын төслийг хянаж, зарчмын зөрүүтэй асуудлаар саналын төсөл боловсруулах;
- Хариуцсан чиглэлээр боловсруулж ирүүлсэн хуулийн үзэл баримтлалын төсөл боловсруулж удирдлагад танилцуулах;
- Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүний санаачилсан хариуцсан чиглэлийн хуулийн тогтоомжийн төсөлд Засгийн газраас өгөх санал, дүгнэлтийн төсөл боловсруулах;

	<ul style="list-style-type: none"> • Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүний санаачилсан хуулийн төслийн үзэл баримтлалд өгөх зөвлөмжийн төсөл боловсруулах; • Хариуцсан чиглэлийн хууль тогтоомжийн төсөлд өгөх саналын төсөл боловсруулах. <p><u>Хуулийн төсөл боловсруулах газарт хамт ажиллаж байсан хүмүүс:</u></p> <p>А.Энх-Эрдэнэ одоо ХЗДХЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч</p> <p>Д.Дуламсүрэн одоо Авилгатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар</p> <p>Э.Энхтуяа одоо ХЗДХЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга</p> <p>Ч.Дондогмаа одоо Засгийн газрын хэрэг эрхлэх газарт ахлах реферант</p> <p>Ч.Бат-Эрдэнэ одоо Төрийн албаны зөвлөлд хэлтсийн дарга</p> <ul style="list-style-type: none"> • ХЗЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын туслахаар 1999-2000 <p>Энэ хугацаанд Хууль зүйн яам /тухайн үеийн нэрээр/-ны Төрийн нарийн бичгийн даргаар Д.Сугар ажиллаж байсан, Үндсэн хуулийн цэцийн гишүүн асан</p> <p><u>Ажлын байрны тодорхойлолтын гол агуулга:</u> Төрийн нарийн бичгийн даргын албан үүргээ гүйцэтгэх хэвийн нөхцөлийг хангаж, туслах</p> <p><u>Хамт ажиллаж байсан хүмүүс:</u></p> <p>Энэ хугацаанд Д.Одбаяр одоо Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Г.Баясгалан одоо Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Д.Мөнхгэрэл одоо Петровис ХК-ийн Хуулийн газрын захирал, Г.Төрбаяр одоо тэтгэвэрт, А.Эрдэнэбулган одоо ХЗДХЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч нар газар, хэлтсийн даргаар ажиллаж байсан.</p> <ul style="list-style-type: none"> • Түүнчлэн 2018-2020 онд Цахилгаан холбоо ХК-ийн ТУЗ-ын гишүүнээр ажиллаж байсан.
Түүнчлэн	<p>Эрх зүйчээс бусад мэргэжлээр эрхэлсэн ажил</p> <p>Их, дээд сургууль төгссөнөөс хойш эрх зүйчээс бусад мэргэжлээр эрхэлсэн ажлыг тодорхойлон бичнэ. Ингэхдээ ажилласан байгууллагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар жагсаах бөгөөд ажил олгогч /эсхүл, удирдах албан тушаалтан/-ийн нэр, хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, цахим хуудас болон ажлын байрны нэрийг бичнэ.</p> <p>Ажиллаж байгаагүй</p>

<p>3.4</p>	<p>Хууль зүйн өндөр мэргэшил</p> <p>Хүсэлт гарагчийг хууль зүйн өндөр мэргэшилтэй /хууль зүйн өндөр мэдлэг, чадвар, туршлагатай, мэргэжлийн өндөр ёс зүйтэй/ гэдгийг нотлон харуулах хамгийн чухал 10 мэргэжлийн үйл ажиллагааг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлох бөгөөд үйл ажиллагаа тус бүрийг явуулсныг нотлох баримтыг хавсаргана. Ийм үйл ажиллагаа тус бүрийн талаар дараах мэдээллийг заавал бичнэ.</p> <ul style="list-style-type: none"> -үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; -үйл ажиллагааны гол агуулга; -үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ; -үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр /нэрс аль болох давхцахгүй байх/, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/; -тухайн үйл ажиллагааны хүрээнд хамтран ажиллаж байсан, өөрийн удирдлагад ажиллаж байсан, ажил хэргийн харилцаатай байсан гурваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/; -хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар. <p>1. Захиргааны хэм хэмжээний актын хяналт бүртгэл (2016 оноос одоог хүртэл)</p> <p>Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу Засгийн газар нь төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын шийдвэр хууль тогтоомжид нийцэж буй эсэхэд хяналт тавих бүрэн эрхтэй.</p> <p>Мөн хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 7-д заасны дагуу төрийн захиргааны байгууллагын шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг хянах асуудал нь Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаардаг бөгөөд энэ үйл ажиллагааг Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолоор баталсан “Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журам”-аар зохицуулж байсныг Улсын Их Хурлаас Захиргааны ерөнхий хуулийг 2015 оны 6 сард баталж, 2016 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр даган мөрдөж эхэлсэнтэй холбогдуулан Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг мөн хуулийн Зургаадугаар бүлгээр зохицуулахаар хуульчилж өгсөн байдаг.</p> <p>Засгийн газрын 119 дүгээр тогтоолын хүрээнд сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, зөвлөл, холбоодын баталсан нийтээр дагаж мөрдөх шийдвэрийг л хянаж бүртгэдэг байсан бол Захиргааны ерөнхий хууль батлагдснаар дээрх албан тушаалтнуудаас гадна мөн хуулийн 5 дугаар зүйлд заасан захиргааны байгууллага, албан тушаалтнуудаас баталсан захиргааны хэм хэмжээний актыг хянаж бүртгэхээр хүрээ нь өргөжсөнтэй холбогдуулан тус яамны бүтцэд Захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийн хэлтсийг байгуулж, тус хэлтсийн даргаар миний бие 2016 оны 8 дугаар сард томилогдон өнөөг хүртэл ажиллаж ирлээ.</p> <p>Захиргааны ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэгт "Захиргааны хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон</p>
-------------------	--

захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй шийдвэрийг ойлгоно" гэж заасан.

Тэгвэл Захиргааны ерөнхий хууль хэрэгжиж эхлэхэд захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын нэгдсэн санд 960 шийдвэр бүртгэлтэй байсан бөгөөд эдгээрээс сайдын 383 тушаал, агентлагийн даргын 56 тушаал, аймаг, нийслэлийн Засаг даргын 44 захирамж нийт 487 шийдвэр нь Захиргааны ерөнхий хуульд заасан шаардлагыг хангахгүй байсан тул хуульд нийцүүлэх арга хэмжээг авахуулахаар холбогдох байгууллага, албан тушаалтанд үндэслэл бүхий дүгнэлт хүргүүлснээр зөрчлийг арилгасан байдаг. Түүнчлэн Захиргааны ерөнхий хуулийн дагуу шинээр орж ирж байгаа захиргааны байгууллагуудын хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрүүдийг санд бүртгэхтэй холбогдуулан татаж үзэхэд хуульд нийцээгүй, хуулиас давсан зохицуулалт бүхий шийдвэрүүд нэлээдгүй байсан бөгөөд ихэвчлэн хуулийн ерөнхий заалтыг үндэслэл болгон хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг баталдаг зөрчил ихээхэн хувийг эзэлж байсныг холбогдох хуульд нийцүүлэн баталж бүртгэх арга хэмжээг авч ажилласнаар 2021 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд сайдын 718, агентлагийн даргын 171, зөвлөл хорооны 242, бүх шатны Засаг даргын 45, бүх шатны ИТХ-ын 534, УИХ-д ажлаа тайлагнадаг 83, төрийн чиг үүргийг хууль болон гэрээний үндсэн дээр гүйцэтгэдэг байгууллагын 11, нийт 1812 шийдвэр бүртгэлтэй болсон байна.

2.Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санг эрхлэн хөтлөх (2016 оноос одоог хүртэл)

Захиргааны ерөнхий хуулийн 72 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд Хууль зүйн сайдын /тухайн үеийн нэрээр/ 2016 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн А/226 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санг эрхлэн хөтлөх журам”-ыг сангийн үйл ажиллагаанд даган мөрдөж ажиллаж байна.

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдсэн шийдвэрийг дээрх хуулийн 67 дугаар зүйлийн 67.1, 67.2 дахь хэсэгт заасны дагуу “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтэлсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдүүлэх болон эмхэтгэлд нийтлэгдсэн шийдвэрийг тухай бүр нь нэн даруй эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд цаг алдалгүй байршуулж төрийн байгууллага болон иргэн, хуулийн этгээдийг мэдээллээр ханган ажиллахад байнгын хяналтыг тавин ажиллаж байна.

3.Иргэд байгууллагыг лавлагаа мэдээллээр хангах (2016 оноос одоог хүртэл)

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй шийдвэрийн талаар иргэн, хуулийн этгээд болон шүүхээс лавлагаа, мэдээлэл авах ажлыг мөн л зохион байгуулж ирлээ.

Эхэн үедээ дээрх этгээдүүдээс ирүүлж байгаа хүсэлтэд заасан нийтээр дагаж мөрдөх шийдвэрүүдийг холбогдох захиргааны байгууллагууд баталж, бүртгүүлдэггүйгээс ихэвчлэн тус санд бүртгэлгүй байна гэсэн хариуг өгч байлаа. Энэ байдал нь нэг талаас нийтээр дагаж мөрдөх дүрэм, журмыг хуулиар дамжуулан шилжүүлэн авсан захиргааны байгууллагуудтай холбоотой асуудал хэдий боловч нөгөө талдаа иргэн, хуулийн этгээдэд захиргааны байгууллагуудаас учруулж байгаа хүнд суртал, чирэгдэл гэж үзсэн тул тус хэлтсээс 2017 оны 7 сард хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бүх хуулиас захиргааны хэм хэмжээний акт гаргах эрх олгогдсон заалтуудын судалгааг хийж байлаа. Судалгааг хийх үед 482 хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан бөгөөд хууль тогтоогч 206 хуулиар дамжуулан нийтдээ 1476 дүрэм, журам батлах эрхийг Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлд заасан захиргааны байгууллагуудад шилжүүлсэн байдаг. Мэдээж судалгаанд хамрагдсан оноос хойш өнөөдрийг хүртэл шинээр олон хууль батлагдаж, түүнчлэн олон хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан эрх олгосон хуулийн заалтад өөрчлөлт орсон байгаа. Тус хэлтэс дээрх судалгааг үндэслэн захиргааны байгууллагуудтай уулзалт хийх, сургалт зохион байгуулах үеэр дээрх тоон мэдээллийг танилцуулах, дүрэм, журмаа баталж бүртгүүлэх шаардлагыг тавьж ажилласнаас гадна 2018 оны 6 сард санд бүртгэлтэй актад хяналт, шинжилгээ үнэлгээг хийж цаашид авах арга хэмжээний талаарх асуудлыг Засгийн газрын хуралдаанд танилцуулснаар 28 дугаар тэмдэглэлийг гарган бүх захиргааны байгууллагуудад зөвлөмж чиглэл өгч ажилласны үр дүнд өнөөдрийн байдлаар 1812 шийдвэр санд бүртгэлтэй болсон байна.

4. Захиргааны байгууллагуудын хэрэгцээ шаардлагад үндэслэн сургалт зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр хангах (2016 оноос одоог хүртэл)

Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд манай хэлтсийнхэн 2017 оны 6 сараас эхлэн он дуустал 21 аймаг болон нийслэлийн 9 дүүрэг, мөн хүсэлт ирүүлсэн захиргааны байгууллагуудад Захиргааны ерөнхий хууль болон Захиргааны хэм хэмжээний актыг хэрхэн боловсруулах, боловсруулалтын шатанд гаргадаг нийтлэг алдаа дутагдал болон бүртгүүлэхгүйгээр дагаж мөрдүүлснээс үүсэх үр дагаврын талаар үе шаттай сургалтуудыг зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллаж ирлээ.

Цаашид санд бүртгэлтэй 1812 шийдвэрийн тоог улам нэмэгдүүлэх, бүртгэлтэй актууд нь шинээр батлагдаж байгаа болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиудад нийцэж байгаа эсэхэд холбогдох захиргааны байгууллагуудтай хамтран хяналт, шинжилгээ үнэлгээний ажлыг үргэлжлүүлэхээс гадна бүртгүүлээгүй мөрдөж байгаа шийдвэрийг бүртгэлд оруулж ирэх, сургалтын захиалга ирүүлсэн захиргааны байгууллагуудтай хамтарч ажиллан мэргэжил, арга зүйгээр ханган ажилласнаар иргэн, хуулийн этгээдэд учирдаг хүнд суртал, чирэгдлийг арилгах, түүнчлэн захиргааны байгууллагуудаас баталдаг нийтээр дагаж мөрдөх дүрэм, журмаар зохицуулж байгаа үйл ажиллагаа нь нийгмийн харилцаагаа бүрэн зохицуулж чадахын сацуу ойлгомжтой тодорхой болох нөхцөлийг бүрдүүлэхээр ажилласаар байна.

Мөн түүнчлэн яамны энэ оны төлөвлөгөөнд 2017 онд хийсэн хуулиар тусгайлан эрх олгогдсон заалтын судалгааг үргэлжлүүлэн байнгын цахим санг бий болгон хөгжүүлэлтийг хийж явснаар хуулийг нэг мөр хэрэгжүүлэх, цаашлаад иргэд, хуулийн этгээдэд учирдаг хүнд суртлыг арилгаж, төрийн байгууллагын үйл ажиллагааг ил тод нээлттэй, ойлгомжтой болоход бодитой хувь нэмрийг оруулан ажиллахаар төлөвлөөд байгаа болно.

Удирдлага: Дээрх ажлуудыг хийж гүйцэтгэх хугацаанд тус яамны Төрийн нарийн бичгийн даргаар Г.Баясгалан /99113819/ одоо Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр ажиллаж байгаа, Г.Билгүүн /99100177/ одоо Иргэний бүртгэлийн ерөнхий газрын дэд даргаар ажиллаж байгаа, Б.Баасандорж /99099609/ одоо ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар ажиллаж байна.

Хамтран ажиллаж байгаа хүмүүс:

Э.Сэлэнгэ одоо ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийн хэлтсийн ахлах шинжээч

М.Мөнх-Алдар одоо ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийн хэлтсийн шинжээч

Б.Даваасүрэн одоо ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

С.Дархантөгс одоо ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Д.Эрдэнэцэцэг одоо ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийн хэлтсийн мэргэжилтэн

5.Хуулийн төсөл боловсруулах (2000-2016)

ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газарт 2000-2016 он хүртэл ажиллаж байхдаа дараахь хуулийн төслүүдийн ажлын хэсэгт эх бичигч, ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж байсан болно. Үүнд:

1. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль болон дагалдан гарсан 200 орчим хууль
2. Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга /эх бичигч/
3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулга /эх бичигч/
4. Нотариатын тухай хуулийн шинэчилсэн найруулга /эх бичигч/
5. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль /эх бичигч/
6. Тахарын (Маршал) албаны тухай хууль /эх бичигч/
7. Яамны эрх зүйн байдлын тухай хууль /эх бичигч/
8. Засгийн газрын агентлагийн тухай хууль /эх бичигч/
9. Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тухай /эх бичигч/

10. Хууль, Улсын Их Хурлын шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн шинэчилсэн найруулга /нарийн бичгийн дарга/
11. Садар самуунтай тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулга /эх бичигч/
12. Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль /ажлын хэсгийн гишүүн/
13. Эрүүл мэндийн тухай хууль /ажлын хэсгийн гишүүн/
14. Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль /ажлын хэсгийн гишүүн/
15. Эмийн тухай хууль /ажлын хэсгийн гишүүн/
16. Боловсролын багц хууль /ажлын хэсгийн гишүүн/ гэх мэт

Удирдлага: Энэ хугацаанд тус яамны Төрийн нарийн бичгийн даргаар Г.Баясгалан одоо Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр ажиллаж байгаа, Ж.Баярцэцэг одоо АНУ-ын Иелийн их сургуульд судлаачаар ажиллаж байгаа, Хууль зүйн бодлогын газрын даргаар Ц.Цолмон одоо Эрдэнэс таван толгой ХК-ийн дэд захирлаар ажиллаж байгаа, Эрх зүйн шинэтгэлийн бодлогын газрын даргаар Т.Бат-Өлзий одоо ХЗДХЯ-ны Олон улсын гэрээ, гадаад хамтын ажиллагааны газрын даргаар ажиллаж байгаа.

Хамтран ажиллаж байсан хүмүүс:

Са.Энхцэцэг одоо УИХ-ын Тамгын газарт зөвлөх

Б.Энхтунгалаг одоо ХЗДХЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт ахлах мэргэжилтэн

Л.Болдхүү одоо Хөгжлийн банкинд хуульчаар ажиллаж байгаа.

6.Бусад яамдаас боловсруулсан хуулийн төсөлд санал өгөх (2000-2016)

ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газарт мэргэжилтэн, ахлах мэргэжилтнээр ажиллаж байх хугацаандаа хуулийн төсөл боловсруулахаас гадна Эрүүл мэндийн яам, Боловсролын яамыг хариуцан ажилладаг байсан бөгөөд тэдгээр яамдаас ирүүлдэг бүх хуулийн төсөлд санал өгч, зарим хуулийн ажлын хэсэгт орж ажиллаж байсан болно. Тухайлбал, Эрүүл мэндийн тухай, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай, Эмийн тухай, Дархлаажуулалтын тухай, Эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүний тухай, Боловсролын багц хууль г.м

Удирдлага: Энэ хугацаанд тус яамны Төрийн нарийн бичгийн даргаар Г.Баясгалан одоо Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр ажиллаж байгаа, Ж.Баярцэцэг одоо АНУ-ын Иелийн их сургуульд судлаачаар ажиллаж байгаа, Хууль зүйн бодлогын газрын даргаар Ц.Цолмон одоо Эрдэнэс таван толгой ХК-ийн дэд захирлаар ажиллаж байгаа, Эрх зүйн шинэтгэлийн бодлогын газрын даргаар Т.Бат-Өлзий одоо ХЗДХЯ-ны Олон улсын гэрээ, гадаад хамтын ажиллагааны газрын даргаар ажиллаж байгаа.

Хамтран ажиллаж байсан хүмүүс:

Г.Сувдаа одоо Ерөнхийлөгчийн тамгын газар реферант

Сү.Энхцэцэг одоо МҮХАТ-ын Арбитрын дарга

Т.Ганбаатар одоо Хуульчдын холбоонд нэгжийн дарга

7.Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүдийн санаачлан боловсруулсан хуулийн төсөлд Засгийн газрын санал дүгнэлтийн төсөл боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх (2000-2016)

Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүдийн санаачлан боловсруулсан 20 орчим хуулийн төсөлд өгөх Засгийн газрын санал дүгнэлтийн төслийг бэлтгэн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн болно.

Удирдлага: Энэ хугацаанд тус яамны Төрийн нарийн бичгийн даргаар Г.Баясгалан одоо Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр ажиллаж байгаа, Ж.Баярцэцэг одоо АНУ-ын Иелийн их сургуульд судлаачаар ажиллаж байгаа, Хууль зүйн бодлогын газрын даргаар Ц.Цолмон одоо Эрдэнэс таван толгой ХК-ийн дэд захирлаар ажиллаж байгаа, Эрх зүйн шинэтгэлийн бодлогын газрын даргаар Т.Бат-Өлзий одоо ХЗДХЯ-ны Олон улсын гэрээ, гадаад хамтын ажиллагааны газрын даргаар ажиллаж байгаа.

Хамтран ажиллаж байсан хүмүүс:

Э.Сэлэнгэ одоо ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийн хэлтсийн ахлах шинжээч

Д.Эрдэнэчимэг одоо өмгөөлөгч

Б.Гантуяа одоо Монголбанкны Ерөнхийлөгчийн зөвлөх

8.Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоолын төсөлд санал өгөх (2000-2016)

ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газарт мэргэжилтэн, ахлах мэргэжилтнээр ажиллаж байх хугацаандаа хуулийн төсөл боловсруулахаас гадна Эрүүл мэндийн яам, Боловсролын яамыг хариуцан ажилладаг байсан бөгөөд тэдгээр яамдаас ирүүлдэг бүх УИХ, Засгийн газрын тогтоолын төсөлд санал өгч байсан болно.

Удирдлага: Энэ хугацаанд тус яамны Төрийн нарийн бичгийн даргаар Г.Баясгалан одоо Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр ажиллаж байгаа, Ж.Баярцэцэг одоо АНУ-ын Иелийн их сургуульд судлаачаар ажиллаж байгаа, Хууль зүйн бодлогын газрын даргаар Ц.Цолмон одоо Эрдэнэс таван толгой ХК-ийн дэд захирлаар ажиллаж байгаа, Эрх зүйн шинэтгэлийн бодлогын газрын даргаар Т.Бат-Өлзий одоо ХЗДХЯ-ны

Олон улсын гэрээ, гадаад хамтын ажиллагааны газрын даргаар ажиллаж байгаа.

Хамтран ажиллаж байсан хүмүүс:

Д.Мөнхцэцэг одоо тэтгэвэрт

Н.Мөнхтуяа одоо ХЗДХЯ-ны Олон улсын гэрээ, гадаад хамтын ажиллагааны газрын ахлах мэргэжилтэн

Х.Сүрэнхорол ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын шинжээч

9.Нотариатын мэргэшлийн хороо (2019-2020)

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны А\213 дугаар тушаалаар Нотаритчийн мэргэшлийн хорооны гишүүнээр томилогдон, гишүүдийн олонхийн саналаар Мэргэшлийн хорооны даргаар сонгогдон ажилласан.

Нотариатчийн мэргэшлийн хороо нь нотариатын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, нотариатын тойрог шилжихтэй холбогдуулж мэргэшлийн шалгалт явуулах, нотариатын мэргэшил, ур чадварын түвшингийн талаар гаргасан эрх бүхий байгууллагын шийдвэр, иргэний өргөдөл, гомдол, хүсэлтэд үндэслэн дүгнэлт гаргах эсэхийг хуралдаанаар олонхийн саналаар шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг болно.

Хамтран ажиллаж байсан хүмүүс:

Б.Бадамханд одоо Монголын нотариатчдын танхимын Удирдах зөвлөлийн гишүүн, нотариатч

Б.Алтантуяа одоо ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газарт шинжээч

А.Энх-Эрдэнэ Нотариатчийн мэргэшлийн хорооны нарийн бичгийн даргаар ажиллаж байсан, одоо ХЗДХЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч

10.Монгол Улсын Шүүхийн ёс зүйн хороо (2019 оноос одоог хүртэл)

Хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас нэр дэвшүүлэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 206 дугаар зарлигаар Шүүхийн ёс зүйн хорооны гишүүнээр томилогдон өнөөдрийг хүртэл ажиллаж байна.

Ажиллах хугацаандаа Шүүхийн ёс зүйн хороонд ирсэн 38 гомдлыг хүлээн авч, хуралдаанаар 14 гомдол, сахилгын хэргийг хянан шийдвэрлүүлж, бусад гишүүдийн 30 гомдол, сахилгын хэрэг хянан шийдвэрлэх хуралдааны бүрэлдэхүүнд ажиллалаа.

Түүнчлэн хэрэг маргаан шийдвэрлэхээс гадна дүрэм журмыг боловсронгуй болгох, шүүгчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар санал бодлоо илэрхийлэн ажиллаж байгаа болно.

Удирдлага: Т.МөнхЭрдэнэ одоо Шүүхийн Ёс зүйн хорооны дарга, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш

Хамтран ажиллаж байгаа хүмүүс:

Д.Эрдэнэчимэг одоо Шүүхийн ёс зүйн хорооны гишүүн

Н.Ганбаатар одоо Шүүхийн ёс зүйн хорооны ажлын албаны дарга

Б.Энхбаатар одоо Шүүхийн ёс зүйн хорооны ажлын албаны реферант

- Дээр дурдсан үндсэн чиг үүргүүдийг хэрэгжүүлж ажилласнаас гадна дараах үнэлгээний хороодыг ахалж ажилласан байна. Үүнд:
 1. Хууль зүй, дотоод хэргийн яамны 2018 оны үйл ажиллагаанд үнэлгээ хийх гүйцэтгэгч сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны даргаар (ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны А\38 тоот тушаалыг хавсаргав)
 2. Хууль тогтоомжийг боловсруулах ажлын хүрээнд хийгдэх зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны даргаар (ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны А\06 тоот тушаалыг хавсаргав)
 3. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр, Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын 2019 оны төлөвлөгөөний хүрээнд улсын төсөв болон гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны даргаар (ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны А\03 тоот тушаалыг хавсаргав)
 4. Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа “Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төсөл”-ийн хүрээнд “Зан үйл хандлагад нөлөөлөх мэдээлэл харилцааны үйл ажиллагаанд үр дүнгийн үнэлгээ хийх” зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны даргаар (ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны А\38 тоот тушаалыг хавсаргав)
 5. Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа “Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хохирогч эмэгтэйчүүдийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны даргаар (ХЗДХЯ-ны

	<p>Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны А\49 тоот тушаалыг хавсаргав)</p> <p>6. Мөн Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа “Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төсөл”-ийн хүрээнд “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хууль зүй, нийгмийн тусламж үйлчилгээ үзүүлэх чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагааг”-г хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны даргаар (ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны А\53 тоот тушаалыг хавсаргав)</p> <p>Түүнчлэн ажиллах хугацаандаа 2002 онд АНУ-ын Туланы их сургуулийн хуулийн сургуульд хуулийн төсөл боловсруулах чиглэлээр, 2017 онд БНСУ-д татварын хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудлаар сургалтад оролцож илтгэл тавьж хэлэлцүүлсэн, 2004 онд Малайз болон БНСУ-д Эрүүл мэндийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох, 2010, 2011 онуудад ХБНГУ, Швед, Шинэ Зеланд, Австрали улсуудад хууль тогтоомжийг боловсронгуй болгох мэргэшүүлсэн сургалтад тус тус хамрагдаж мэдлэг, мэргэшлээ дээшлүүлсэн байна.</p>
<p>3.5</p>	<p>Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар</p> <p>Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, хууль зүйн эсхүл хүний эрхийн чиглэлээр ажилладаг бусад холбоо, байгууллагад гишүүн бол хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар нэрлэн бичиж, гишүүнчлэл тус бүрийг нотлох баримтыг хавсаргана.</p> <p>-Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүн болсон огноог бичнэ. Уг байгууллагын гишүүнчлэлийг түдгэлзүүлж, хүчингүй болгож, дуусгавар болгож байсан бол энэ талаар бичиж, шалтгааныг нь тайлбарлана.</p> <p>-Мэргэжлийн холбоо, байгууллагад эрхэлж байсан албан тушаал, гүйцэтгэсэн чиг үүргийн нэр, огноог хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичнэ.</p> <p>Үгүй</p>
<p>3.6</p>	<p>Байгаа бол хэвлүүлсэн бүтээл болон олон нийтэд өгсөн мэдээлэл</p> <p>-Өөрийн боловсруулсан, хянасан ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ.</p> <p>-Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ.</p> <p>-сүүлийн таван жилийн хугацаанд хэлэлцүүлсэн лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, ярианы товч утга, огноо, газар, танилцах арга замыг бичнэ. Тухайн илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол</p>

түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч утгыг бичнэ.

-сүүлийн таван жилийн хугацаанд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлага, нийтлэлийг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлага, нийтлэлүүдийн огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэг, нийтлэлийг хуулбарлан өгнө.

Жич: Дээр дурдсан материал тус бүрээс нэгийг хавсаргах бөгөөд боломжтой бол цахимаар үзэх линкийг тусгана.

- ХЗДХЯ, Швейцарийн хөгжлийн агентлагийн хамтарсан “Иргэдийн оролцоо II” төслийн захиалгаар хийсэн Иргэний оролцооны зохицуулалт бүхий захиргааны хэм хэмжээний актад хийсэн дүн шинжилгээ товхимол (2018)-д мэргэжил арга зүйгээр тусалж хамтран ажилласан. (товхимолыг хавсаргав)
- Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас захиргааны хэм хэмжээний акт батлан гаргахад зориулсан гарын авлага (2020)-ыг боловсруулахад хамтран ажилласан. (гарын авлагыг хавсаргав)
- Жил бүр гаргадаг Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлийг хянаж хэвлэлтэд гаргадаг. (2021 оны эмхэтгэлийг хавсаргав)
- Захиргааны байгууллага болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд зөвлөмж боловсруулж хүргүүлсэн. (зөвлөмжийг хавсаргав)
- Нөлөөллийн шинжилгээ хийх аргачлалыг боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А\147 дугаар тушаалаар батлуулсан. (тушаалыг хавсаргав)
- Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд 2017 оны 6 сараас эхлэн он дуустал 21 аймаг болон нийслэлийн 9 дүүрэг, мөн хүсэлт ирүүлсэн захиргааны байгууллагуудад Захиргааны ерөнхий хууль болон Захиргааны хэм хэмжээний актыг хэрхэн боловсруулах, боловсруулалтын шатанд гаргадаг нийтлэг алдаа дутагдал болон бүртгүүлэхгүйгээр дагаж мөрдүүлснээс үүсэх үр дагаврын талаар үе шаттай сургалтуудыг зохион байгуулж, нээлтийн үг, илтгэл мэдээллүүдийг тавьж мэргэжил арга зүйгээр ханган ажиллаж ирлээ. Энэ ажлын хүрээнд иргэд, албан тушаалтанд зориулж Захиргааны ерөнхий хуулийн гарын авлагыг боловсруулж 10000 ш хэвлэн 21 аймаг, 9 дүүрэг болон бусад захиргааны байгууллагад хүргүүлсэн болно. (гарын авлагыг хавсаргав)
- ХЗДХЯ-аас жил бүр зохион байгуулдаг Аймгуудын ЗДТГ-ын хуулийн хэлтсийн дарга нарын сургалтад 2016 оноос хойш Захиргааны хэм хэмжээний актын талаар илтгэлийг 4 удаа тавьсан байна.

Илтгэл мэдээлийн гол агуулга нь Захиргааны ерөнхий хууль болон Захиргааны хэм хэмжээний актыг хэрхэн яаж боловсруулах,

боловсруулалтын шатанд гаргадаг нийтлэг алдаа дутагдал болон бүртгүүлэхгүйгээр дагаж мөрдүүлснээс үүсэх үр дагаврын талаар болон жил бүрийн захиргааны хэм хэмжээний актын хяналт бүртгэлтэй холбогдох мэдээллийг хүргэдэг болно.

- Түүнчлэн ХЗДХЯ-нд ажиллах хугацаандаа дээр дурдсан 20 орчим хуулийн төслийн танилцуулга, үзэл баримтлал, сайдын хэлэх үгүүдийг бэлтгэж, хуулиудыг олон нийтээр хэлэлцүүлэхэд биечлэн оролцож байсан болно.
- 2016 онд Захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийн даргаар томилогдоход захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын нэгдсэн санд 960 шийдвэр бүртгэлтэй байсан бөгөөд эдгээрээс сайдын 383 тушаал, агентлагийн даргын 56 тушаал, аймаг, нийслэлийн Засаг даргын 44 захирамж нийт 487 шийдвэр нь Захиргааны ерөнхий хуульд заасан шаардлагыг хангахгүй байсан тул хуульд нийцүүлэх арга хэмжээг авахуулахаар холбогдох байгууллага, албан тушаалтанд үндэслэл бүхий дүгнэлт бичин хүргүүлснээр зөрчлийг арилгасан байдаг. Түүнчлэн Захиргааны ерөнхий хуулийн дагуу шинээр орж ирж байгаа захиргааны байгууллагуудын хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрүүдийг санд бүртгэхтэй холбогдуулан 1000 гаруй актыг татаж үзэхэд хуульд нийцээгүй, хуулиас давсан зохицуулалт бүхий шийдвэрүүд нэлээдгүй байсан бөгөөд ихэвчлэн хуулийн ерөнхий заалтыг үндэслэл болгон хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг баталдаг зөрчил ихээхэн хувийг эзэлж байсныг холбогдох хуульд нийцүүлэн баталж бүртгэх арга хэмжээг авч ажилласнаар 2021 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд сайдын 718, агентлагийн даргын 171, зөвлөл хорооны 242, бүх шатны Засаг даргын 45, бүх шатны ИТХ-ын 534, УИХ-д ажлаа тайлагнадаг 83, төрийн чиг үүргийг хууль болон гэрээний үндсэн дээр гүйцэтгэдэг байгууллагын 11, нийт 1812 шийдвэр бүртгэлтэй болсон байна. Үүнээс үзэхэд сүүлийн 5 жилийн хугацаанд давхардсан тоогоор 3000 орчим захиргааны хэм хэмжээний актыг биечлэн хянаж, бүртгэх, буцаах, хүчингүй болгох сайдын албан бичгийг төлөвлөж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн байна.

/Хянаж бүртгэсэн захиргааны хэм хэмжээний актыг <https://www.legalinfo.mn/law/?cat=35>, <https://www.legalinfo.mn/law/?cat=37>, <https://www.legalinfo.mn/law/?cat=34>, [/https://www.legalinfo.mn/law/?cat=38](https://www.legalinfo.mn/law/?cat=38) линкээр үзнэ үү/

- 2016 онд МҮОНТ-ийн Хуулийн цаг нэвтрүүлэгт Захиргааны ерөнхий хууль, захиргааны хэм хэмжээний актын талаар ярилцлага, 2018 онд Авилгатай тэмцэх газраас бэлтгэсэн “Авилгагүй нийгмийн төлөө хамтдаа” МҮОНТ-ийн нэвтрүүлэгт орж ярилцлага өгч байсан болно. Мөн 2016 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн Өнөөдөр сонины Албаны хүний үг буланд “120 гаруй тушаал, шийдвэрийг хүчингүй болгоно” гарчигтай ярилцлага хэвлэгдсэн. /Телевизийн ярилцлагыг

Хавсралт:

Нэр дэвших тухай хүсэлтэд журмын 5.1-д заасан дараах баримт бичгийг хавсаргана:

- төрийн албан хаагчийн анкет;
- иргэний үнэмлэхийн хуулбар;
- нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар, эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг;
- эрх зүйн бакалаврын, эсхүл түүнээс дээш боловсролын зэргийн дипломын хуулбар;
- хууль зүйн өндөр мэргэшилтэй гэдгийг нотлох харуулсан үйл ажиллагааны талаарх баримт;
- эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласныг нотлох баримт;
- хүсэлт гаргагчийн талаарх тодорхойлолт /гурваас доошгүй/;
- энэхүү загварт заасан баримт бичиг;
- холбогдох бусад баримт.

Хүсэлт гаргагч:

Эцэг/эхийн нэр: Доржгочоо

Өөрийн нэр: Ариунтуяа

Гарын үсэг:

Он, сар, өдөр: 2021 оны 3 дугаар сарын 30-ны өдөр

--- оОо ---